



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 469

Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.15-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралт, "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм"-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
- 2.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм, журам батлах тухай" Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 354 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА